



БОДЬ ДААТГАЛ
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

**2020 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**



Бодь даатгал ХК нь 1995 оны 2 сарын 05-ны өдрийн 154 дугаар хурлын тогтоолоор “И Би Эйч Бодь Даатгал ХХК” нэртэй үүсэн байгуулагдаж, Соёлын Төв Өргөөний 5 давхарт үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлжээ.

Компани өдгөө 21 аймаг 330 сум, 26 салбар, 200 гаруй ажилтан, албан хаагч, 800 гаруй төлөөлөгч болон банкны даатгалын сүлжээгээр дамжуулан орон даяар даатгалын үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэж байна. 2020 онд оновчтой зөв, цахим технологиудыг анхлан нэвтрүүлснээр үр ашиггүй зардал буурч бүтээгдэхүүн үйлчилгээг шинэчлэн сайжруулж нөхөн төлбөр шийдвэрлэлтийн дундаж хугацаа буурлаа.

Дэлхийн тэргүүлэх №1 даатгалын AXA группийн цорын ганц төлөөлөгчөөр сонгогдож олон улсын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг Монгол хүний эрүүл мэндийн онцлог болон санхүүгийн чадварт нийцүүлэн Монголын даатгалын зах зээлд олон улсын эрүүл мэндийн даатгалыг тогтвортойгоор нутагшуулж чадлаа.

Бид хэрэглэгчдийн амьдралын хэв маяг, харилцагчдынхаа эрхэлж буй бизнесийн онцлогт тохируулан тэдний хэрэгцээ, шаардлага, хүсэл сонирхолд нийцүүлэн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг тусгайлан боловсруулж ажилладаг.

Бодь даатгал компани 2020 онд компанийн ашигт ажиллагааг өсгөх, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх зорилт тавин ажилласнаар insuretech технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн салбарын хэмжээнд хамгийн их нөхөн төлбөрийг олгож хураамжийн орлогоороо тэргүүлсэн нь даатгалын салбартаа тэргүүлэгч байр суурийг хадгалсаар байна.

Нөхөн төлбөр 8.6 тэрбум ₮

салбартаа **№1**

Нийт хураамж 34.1 тэрбум ₮

салбартаа **№1**



АЛСЫН ХАРАА

АЗИД БҮРТГЭЛТЭЙ ЕРДИЙН БОЛОН АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН КОМПАНИ БОЛНО.

2030 он гэхэд Хонконгийн хөрөнгийн биржийн 2-р самбарт бүртгэлтэй, Азид өрсөлдөгч санхүүгийн цогц хамгаалалт үзүүлэгч компани болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

ХАМТЫН ХҮЧЭЭР ИРЭЭДҮЙГ БАТАЛГААЖУУЛНА.

Хамтын хүчээр санхүүгийн нөөцөө бүрдүүлж харилцагч бүр ирээдүйгээ төлөвлөхөд нь тусалж түүнд учирч болох эрсдэлээс хамгаалах хүчирхэг санхүүгийн компани эрсдэлийн зөвлөх болно.



ҮНЭТ ЗҮЙЛС

Харилцагч эрхэм

Харилцагчаа халамжлан сэтгэл хангалуун байлгахын төлөө нөөц боломжийг бүрэн ашиглана.

Мэргэжлийн байх

Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн, үр чадвараа дайчлан олон улсын түвшинд ажиллана.

Ухаалаг ажиллах

Шинийг санаачилж, бүтээмжтэй, багаар ажиллана.

Хамтын хөгжил

Урт хугацааны тогтвортой, хамтын хөгжлийг эрхэмлэнэ.

Хариуцлага

Бүх түвшинд нягт нямбай, хариуцлагатай, нээлттэй байна.



2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛААС:

01

Бодь Даатгал ХК 2020 оны 6 сард Монголын хөрөнгийн биржээр дамжуулан тухайн жилийн анхны IPO хийж олон нийтэд нийт хувьцааныхаа 20 хувийг санал болгож нийт 5.3 тэрбум төгрөгийн хувьцааг эзэмшүүлснээр нээлттэй хувьцаат компани боллоо.

02

Хувь хүн, байгууллагын санхүү бизнесийн тогтвортой байдлыг ханган эрсдэлийн менежментийг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлснээр 2020 онд даатгалын салбартаа хамгийн өндөр хураамж буюу нийт 34.1 тэрбум төгрөгийн хураамжийг төвлөрүүлж өмнөх оноос 22.1 хувиар нэмэгдүүлж чадлаа.

03

Ковид-19 вирусн нөлөөгөөр 2020 онд Монгол улсын бодит эдийн засаг өмнөх оноосоо 10%-иар, даатгалын салбарын цэвэр хураамжийн орлого 4%-иар тус тус буурсан ч Бодь даатгал компанийн цэвэр хураамж 2020 онд 14.67 т.б төгрөг болж өмнөх оноос 4.5%-иар өссөн.

04

Гадаадын нэр хүндтэй, тэргүүлэх давхар даатгагчдад 19.4 тэрбум төгрөгийн хураамж бүхий даатгалыг шилжүүлж, үүнээс 1.2 тэрбум төгрөгийн шимтгэлийг хуримтлуулсан нь даатгалын салбар дахь давхар даатгалын шимтгэлийн орлогын 70%-ийг дангаараа эзэлж байна.

05

Компанийн үйл ажиллагааг 80 хувиас дээш цахимжуулах зорилтын хүрээнд цахим оффисийг бүрэн нэвтрүүлж, харилцагч даатгуулагчийн нөхөн төлбөрийг хамгийн богино хугацаанд шийдвэрлэн салбартаа хамгийн их буюу 8.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 12 мянга гаруй даатгуулагч иргэн, байгууллагад 100% шийдсэн.

06

Компани 2020 онд хэрэглэгчдийн эрэлтэд нийцсэн 3 шинэ бүтээгдэхүүн зах зээлд амжилттай хөгжүүлж нэвтрүүлээ. Мөн эрүүл мэнд, тээврийн хэрэгсэл, зуслангийн байшингаа хүн бүр өөрийн ажил гэрээсээ онлайнаар даатгуулах боломжийг бий болгоод байна.

07


Хөдөө орон нутгийн 21 салбараар дамжуулан борлуулсан бүтээгдэхүүнээс хамгийн их хувийг малын индексжүүлсэн даатгал эзэлдэг бөгөөд 2020 онд тус бүтээгдэхүүний салбарын хураамжийн 25%-ийг бүрдүүлсэн байна.

БИЗНЕСИЙН БАЙДАЛ


2020 онд хөл хорио тогтоож, хил хааж, бизнесийн орчны тодорхойгүй байдал үүссэнээр Монгол улсын бодит эдийн засаг 5.3% буурсан байна. Манай компаний хувьд цэвэр хураамж төлөвлөж байсан хэмжээнд хүрээгүй боловч, өнгөрсөн оноос 4.5%-иар өсөж, нийт даатгалын зах зээлд эзлэх хувь 10.8%-иас 11.7% болж 0.9 пунктээр өслөө. Даатгалын салбарын цэвэр хураамж 4%-иар буурсан байна.

Цэвэр ашгийн хэмжээ 2020 онд 1.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 14%-иар өссөн бөгөөд энэ нь ердийн даатгалын салбарын цэвэр ашгийн 11%-ийг бүрдүүлж байна.


НИЙТ ХУРААМЖ



ЦЭВЭР ХУРААМЖ



ЦЭВЭР АШИГ



Зах зээлд эзлэх хувь	2018	2019	2020 ¹
Зах зээлд эзлэх хувь	20%	14%	17%
Зах зээлд эзлэх хувь	9.8%	10.8%	11.7%
Зах зээлд эзлэх хувь	17%	10%	11%

Олон улсын жишгээр иргэдийн орлого өсөхөд даатгалын бүтээгдэхүүний эрэлт өсдөг. Хэдийгээр өнгөрсөн онд нэг хүнд ногдох ДНБ 3990 ам доллар болж буурсан боловч нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлттэй холбоотойгоор иргэдийн гар дээр очих бэлэн мөнгөний орлого нэмэгдсэн нь даатгалын эрэлтийн өсөлтөнд эерэгээр нөлөөлсөн байх магадлалтай байна. 2020 оны эхний улиралд удирдлагын багаас шийдвэр гаргаж банкны зуучлалаар төвлөрүүлдэг зээлийн эрсдэлийн даатгалыг эрсдэл хаах үүднээс зогсоосон бөгөөд өмнөх жилийн Зээлийн эрсдэлийн даатгалын дүнг хассан дүнгээр манай цэвэр хураамж 8.1% өссөн байна.

1. 2020 оны тайлан аудитлагдаагүй.

Манай улсад сүүлийн үед иргэд, байгууллагын зүгээс даатгалын бүтээгдэхүүнийг хэрэглэж хэвших соёл, дадал хандлага нэмэгдэж байгаа нь эдийн засгийн сааралтаас үл хамааран даатгалын бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлж байна.

Бид харилцагчдын эрэлт болон хүсэл сонирхол, хэрэглээний тохиромжтой байдалд нийцүүлсэн тээврийн хэрэгслийн болон эрүүл мэндийн шинэ бүтээгдэхүүнүүд нэвтрүүлсэн нь мөн ашиг орлого нэмэгдэхэд нөлөөллөө. Цаашид ч шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг өргөжүүлэх нь бидний байнгын зорилго байх болно.



Даатгалын төрлүүдээр авч үзвэл жолоочийн хариуцлагын даатгалын нэвтрэлт ханасан, замын хөдөлгөөн хязгаарласан тул буурч, харин хөрөнгийн даатгалын нэг төрөл болох тээврийн хэрэгслийн даатгал өссөн.



2020 онд бизнесийн тодорхойгүй байдлын улмаас компаниуд бэлэн мөнгөний түр нөөцлөлт хийж, хариуцлагын болон хөрөнгийн даатгал буурсан боловч, байгууллагууд ажилчдынхаа эрүүл мэндийг 1-т тавьж даатгуулснаар эрүүл мэндийн даатгал 36.8% өсөлт үзүүлснийг онцлон тэмдэглэж байна. Эрүүл мэндийн даатгалаар манайх үргэлж тэргүүлэгч байсаар ирсэн. Ерөнхийдөө эдийн засгийн өсөлт тогтворжсон улсад байгууллага, бизнес бүр орлогынхоо дор хаяж 1%-ийг эрсдэлийн менежмент, даатгалын зардалд зарцуулдаг.

ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Дэлхийн №1 даатгалын болон хөрөнгө, санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэгч АХА компанийн Монгол дахь цорын ганц төлөөлөгч Бодь даатгал компани 2015 оноос олон улсын эрүүл мэндийн даатгалыг монгол хүний онцлогт тохируулан боловсруулж монгол хүн дэлхийн хаана ч санхүүгийн асуудалд санаа зоволгүйгээр эмчилгээ үйлчилгээнд бүрэн хамрагдах BODI+Global Healthcare олон улсын эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлсэн.

BODI+

Global Healthcare



Томоохон эмнэлгүүдэд шууд төлбөрийн үйлчилгээ




Салбартаа олон жил ажилласан туршлагатай нөхөн төлбөрийн зөвлөх эмч



Эрүүл мэндийн даатгалын чиглэлээр мэргэшсэн даатгалын андеррайтингийн баг



Таны эрүүл мэнд болон хувийн нууцлалыг дэлхийн түвшний өндөр стандартаар хамгаална.



Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамгаалалт



Таны эрүүл амьдралын хэв маягт дэмжлэг үзүүлэх халамжийн бодлого

Хөдөө орон нутгийн 21 салбараар дамжуулан борлуулсан бүтээгдэхүүнээс хамгийн их хувийг малын индексжүүлсэн даатгал эзэлдэг бөгөөд 2020 онд компани тус бүтээгдэхүүний салбарын хураамжийн 25%-ийг бүрдүүлсэн байна.



Бүтээгдэхүүнээр:	FY19	FY20	YoY%
Жолоочийн хариуцлага:	4,569.7	4,754.2	4.0%
Тээврийн хэрэгсэл:	2,372.4	2,694.2	13.6%
Эрүүл мэнд:	2,897.5	3,964.8	36.8%
Хөрөнгө:	990.46	963.5	-2.7%
Хариуцлага:	1,592.9	1,347.7	-15.4%
Мал амьтад:	778.3	574.2	-26.2%
Бусад:	830.9	369.9	-55.5%
Цэвэр хураамж	14,032.0	14,668.4	+4.5%

Бүсээр (сая төг)	FY19	FY20	YoY%
УБ хот иргэд	4,582.8	5,357.4	16.9%
Орон нутаг иргэд	2,722.4	2,304.0	-15.4%
Нийт иргэд:	7,305.1	7,661.4	4.9%
Хөрөнгө, хариуцлага:	3,609.2	4,254.0	17.9%
Эрүүл мэнд:	1,414.2	1,802.0	27.4%
Шууд бус (Брокер):	1,703.7	951.0	-44.2%
Байгууллага нийт:	6,727.1	7,007.0	4.2%
Цэвэр хураамж:	14,032.3	14,668.4	+4.5%

Бид 5 сая төгрөгийн жолоочийн хариуцлагын даатгалаас, эдийн засагт шууд нөлөө үзүүлэхүйц томоохон үйл ажиллагаатай харилцагчийн 1 тэрбум ам.доллар хүртэлх эрсдэлийн даатгалыг өөрийн болон гадаадын давхар даатгагчид шилжүүлсэн гэрээ хийж ажиллалаа. Бид дотооддоо буюу өөр дээрээ 50,000 ам.долларын эрсдэл авч, давсан хэсгийг гадаадын төлбөрийн чадварын үнэлгээтэй томоохон даатгагч нарт шилжүүлдэг. 2021 оны бизнесийн өсөлтөд зориулан 2020 онд давхар даатгалын гэрээний хамгаалалтаа 2 дахин сайжруулсан.

ДАВХАР ДААТГАГЧИД БОЛОН ЗУУЧЛАГЧИД:



ДААТГАЛЫН ЭРЭЛТ

Эдийн засгийн хөгжлийн үр дүнд томоохон шинэ зах зээлүүд үүсэж бий болсноор даатгалын эрэлт нэмэгдэж байна.

Өмнө дурьдсанаар 2020 онд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн буурч 3990 ам.доллар гарсан боловч, цаашдын дунд хугацаанд өсөлттэй байх төлөвтэй байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4800 ам.долларт хүрснээр даатгалын нэвтрэлт хамгийн хурдтай нэвтэрч эхэлдэг гэж гадаадын судлаачид үздэг². Одоогийн байдлаар манай улс энэ хэмжээнд хүрээгүй боловч даатгалын салбарын өсөлт улсын эдийн засгийн өсөлтөөс дор хаяж 1.5 дахин хурдтай байна. Эдийн засаг өндөр хөгжсөн улс орнуудын жишээнээс харахад иргэд, байгууллагууд нь жилд улсын эдийн засгийнхаа 4%-6%-тай тэнцэх хэмжээний дүнгээр эрүүл мэнд, хөрөнгө, хариуцлага, бизнесийн тогтвортой байдлаа даатгадаг бол манай улсын хувьд тухайн үзүүлэлт 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар жилийн дүнгээр 0.5% орчим байна.

Бодь даатгал компанийн эрсдэл, судалгааны хэлтсээс Иргэд, байгууллагын ашиг орлого нэмэгдсэнээр энэ дүн цаашид хурдацтай өсч 2025 онд 1% хувьд хүрэх боломжтойг тооцсон. Тухайлбал манай улсын эдийн засгийн багтаамж Олон улсын валютын сангийн 2025 оны төсөөллөөр нэг хүнд ногдох ДНБ 5200 ам.долларт буюу нийтээрээ 60 их наяд³ төгрөгт хүрвэл үүний 1% буюу нийт 600 тэрбум төгрөгийн цэвэр хураамж, нийт хураамж 1 их наяд төгрөгийн хураамж бүрдүүлэх боломжтой гэж бид тооцож байна. Даатгалын үйл ажиллагаа нь банк, хөрөнгийн биржийн үйл ажиллагааны нэгэн адил эдийн засгийг удаашруулахгүй, зогсоохгүй байлгах зайлшгүй үүрэгтэйгээр ажиллах зарчимтай.

IMF төсөөлөл	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нэг хүнд ногдох ДНБ \$	3595	4057	4200	3990	4139	4397	4667	4932	5200
									төсөөлөл

Бид даатгалын нэвтрэлтийг энэ хувьд хүргэхэд тэргүүлэн оролцохоор төлөвлөж, зах зээлийн тэргүүлэгч даатгагч байгууллага болох зорилт тавин ажиллах болно.

2. Эх сурвалж: (The S-Curve Relation Between Per-capita income and insurance penetration by Rudolf Enz)
3. Хүн амын өсөлтийг жил бүр 2%, долларын ханшыг 3107 төгрөгөөр тооцоолсон

ДИЖИТАЛ, ОРЧИН ҮЕИЙН ТЕХНОЛОГИ АШИГЛАЛТ

2020 оны хураамжийн өсөлтөд даатгалын нэвтрэлт бага байгаа нь нөлөөлснөөс гадна манай харилцагчдын зүгээс байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид өгөх сэтгэл ханамжийн түвшин өндөр, байнгын харилцагчдын тоо тогтвортой байгаа зэрэг нь нөлөөллөө. Тухайлбал бидэнтэй хамтарсан 10 харилцагчийн 9 нь цаашид үргэлжлүүлэн хамтран ажиллаж байдагт туйлын их талархалтай байна.

Цар тахлын хөл хорионы улмаас улсын эдийн засгийн үзүүлэлтүүд эхний 1 улиралд огцом буурахад үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд бид өмнө туршиж дадаад байсан технологийн дэвшил, дижитал программууд болон харилцаа холбооны орчин үеийн аргачлалуудыг ашиглаж ирлээ. Цаашид бид дээрх бүх арга, хэрэгслийг үйл ажиллагаандаа аль болох өргөнөөр ашиглахыг эрмэлзэх бөгөөд компанийнхаа соёл, эрхэмлэх үнэт зүйлсдээ технологи ашиглалтыг нэгэн чухал үзүүлэлтээр тооцон явж байна.

Мөн insurtech-ийн хамгийн сүүлийн үеийн чиг хандлагыг шингээсэн орчин үеийн программ хангамж, технологиор ажиллах, даатгагчиддаа дунд хугацаандаа эрсдэл бууруулах төхөөрөмжүүд санал болгох, даатгалын үйлчилгээний орчин үеийн шийдлүүдийг хүргэхээр судалж, зорин ажиллах болно.

Боломж:

- Нэгдмэл, өндөр хурдаар, багаар харилцах
- Ажлын үр ашиггүй шат дамжлагыг багасгах
- Мэдээллийн урсгалыг шуурхай болгох

Системд нэгтгэсэн:

- Борлуулалтын суваг
- Борлуулалт
- Андеррайтинг
- Нөхөн төлбөр
- Харилцагчийн үйлчилгээ

The screenshot displays the ONCONTACT CRM interface. The left sidebar contains navigation icons for Workspace, Contacts, Companies, Activities, Incidents, Opportunities, Defect, New, Dashboards, Recents, and Favorites. The main content area is titled 'Company Details' and shows information for 'ABC Company'. It includes sections for 'Addresses (1 of 2)', 'Phones (1 of 2)', 'Web Addresses (1 of 1)', 'Type' (Active Customer), 'Status' (Prospect - Hot), 'Profile' (Consulting Services), 'Representatives (1 of 1)' (Sales User), and 'Territories (0)'. A 'Summary' section at the bottom features four colored boxes: '1 Active Opportunities' (green), '1 Open Incidents' (blue), '4 To Do's' (red), and '\$0.00 Month To Date Sales' (yellow). On the right, a 'Contacts' list shows five entries with profile pictures and names: Carrie Jackson, Ellen Hazard, Harry Thompson, Melaney Ricardo, and Michelle Roberts. Below this is a 'Recent Activity' section with a list of events, including an appointment on April 7, 2017, and a telephone call on September 11, 2016.

ЛИЙД МЕНЕЖМЕНТ



Бүхий л сувгаар орж ирсэн даатгуулагч болох хүсэлтийг алдалгүй бүртгэн авч үйлчилгээ үзүүлнэ.

Боломж:

- Санал хүсэлт бүрийг системд хүлээж авах, нэгтгэх
- Харилцагчийн мэдээллийн бааз үүсгэх

Санал хүсэлт:

- Утас
- И-мэйл
- Бусад сошиал сувгууд



ЦАХИМ ДААТГАЛ

Манай компани одоогоор хамгийн олон буюу 70 гаруй бүтээгдэхүүнтэй, үүнээс 33 даатгалыг хэрэгдэгчдэд голчлон хүргэж үйлчилж байна. 2020 онд хэрэглэгчдэд даатгалын үйлчилгээг ойртуулахаар 11 даатгалыг 100% цахимжуулж хүн бүр өөрийн гэрээсээ, ажлаасаа даатгуулах боломжийг бий болгоод байна.



www.bodi-insurance.com



ЭРҮҮЛ
МЭНДИЙН
ДААТГАЛ



ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН
ДААТГАЛ



ГЭНЭТИЙН
ОСЛЫН
ДААТГАЛ



ЗУСЛАНГИЙН
БАЙШИНГИЙН
ДААТГАЛ



ӨМГӨӨЛӨГЧИЙН
ХАРИУЦЛАГЫН
ДААТГАЛ



ИПОТЕКИЙН
ДААТГАЛ




ТҮРЭЭСЛЭГЧИЙН
ХАРИУЦЛАГЫН
ДААТГАЛ



ХУРДАН МОРЬ
УНААЧ ХҮҮХДИЙН
ДААТГАЛ

НӨХӨН ТӨЛБӨР

Зардалд тооцсон нөхөн төлбөрийг орлогод тооцсон хураамжтай харьцуулсан хохирлын харьцаа (Харьцуулалт)



“ 2020 онд нийт 12,100 даатгалын тохиолдолд 8.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. ”

Нөхөн төлбөрийн үйлчилгээний хурдыг нэмэгдүүлэх дараах 3 чухал ажлыг хэрэгжүүллээ.

1

Зам тээврийн ослын баримтжуулсан зургийг цахимаар хүлээн авч зөвлөгөө өгдөг боллоо.

2

Хохирлын материал, үнэлгээг цахимаар авдаг боллоо

3

Ослын газар дээр нь нөхөн төлбөрийг шийдвэрлэн олгож байна.

IPO

Компани 2020 оны 6 сард тухайн жилийн анхны IPO хийж олон нийтэд хувьцаагаа 113 төгрөгөөр арилжиж эхэлснээс хойш 2020 оны 12 сарын 31-н хүртэл хагас жилд 14%-иар өсөж 129 төгрөгөөр хаагдлаа. Манай компанийн хөрөнгө оруулагч хувьцааны үнийн өсөлт болон ногдол ашгаас нийтдээ жилийн 22%-ийн өгөөжтэй* гарлаа. Улмаар 2020 оны хамгийн идэвхтэй бөгөөд тогтмол арилжигдсан хувьцаа болж ТОП-20 индекст орсон нь даатгалын салбарт иргэдийн итгэл өндөр байгааг батлан харуулж байна.



Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтүүдээр үнэлж, жил бүр тус багцыг шинэчилдэг бөгөөд 2020 оны 6 сард анхны хувьцаагаа гарган хувьцаат компани болсон Бодь Даатгал ХК ТОП20 индекст багтаж салбартаа тэргүүлэгч гэдгээ батлан харууллаа.


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТОП 20 ИНДЕКС

№	Үнэт цаасны нэр	Зах зээлийн үнэлгээ	Арилжигдсан үнийн дүн	Арилжаанд орсон өдөр /248 өдөр/	Өдрийн дундаж гүйлгээ
1	"АПУ" ХК	643,989,466,798	2,427,701,174	248	9,789,118
2	"Монгол шуудан" ХК	74,689,772,250	3,050,900,547	152	12,302,018
3	"Ард санхүүгийн нэгдэл" ХК	50,303,874,354	4,411,534,408	244	17,788,445
4	"Инвексдор ББСБ" ХК	212,386,365,198	911,553,987	247	3,675,621
5	"Тавантолгой" ХК	371,816,312,000	629,957,389	241	2,540,151
6	"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"	229,845,710,094	662,167,207	202	2,670,029
7	"Говь" ХК	150,171,656,250	780,044,366	247	3,145,340
8	"БОДЬ ДААТГАЛ" ХК	30,591,563,340	1,085,468,722	112	4,376,890
9	"Ард кредит ББСБ" ХК	22,988,000,000	2,190,301,292	241	8,831,860
10	"ЛэндМН ББСБ" ХК	25,152,000,000	1,599,723,505	247	6,450,498

* — Нийт өгөөж = ((Оны эцсийн үнэ + Ногдол ашиг)/IPO үнэ) ^ (4/30/2021 - 6/9/2020)

САНХҮҮГИЙН БАЙДАЛ


2020 онд нийт 34.1 тэрбум төгрөгийн хураамж цуглуулснаас, 57%-ийг гадагш шилжүүлж, 43%-ийг цэвэр хураамж болгон өөрт хариуцан үлдээсэн. Нийт хураамж нь салбарын 17%-ийг, цэвэр хураамж нь салбарын 11.7%-ийг эзэлж байна. Давхар даатгагчид шилжүүлсэн хураамжаас дунджаар 6% шимтгэл авч үлдсэн нь салбарын дунджаас 5%-иар илүү байгаа нь давхар даатгагч нартай олон жил үнэнчээр, найдвартайгаар ажилласантай холбоотой. Мөн давхар даатгагч руу шилжүүлсэн хураамжаас 600 сая төгрөгийн хураамжийг өөрийн хариуцах хэсгийн хураамж болгон авсан. Давхар даатгалын гэрээний 10% хүртэлх хэсгийг Бодь даатгал өөрөө хариуцдаг.



2020 онд нийт 118.8 мянган даатгуулагчаас дунжаар 287.2 мянган төгрөгийн хураамж цуглуулж, нийт 12.1 мянган даатгуулагчид дунджаар 711 мянган төгрөгийн нөхөн төлбөр нийтдээ, 8.6 тэрбум төгрөгийн хохирол төлсөн байна. Энэ нь салбарын хамгийн өндөр үзүүлэлт юм. Үүнээс 2 тэрбумыг нь давхар даатгагчаас хариуцлаа.

2020 оны тайланд 14.7 тэрбум төгрөг орлогод тооцсон. Үүнээс 6.0 тэрбум төгрөг нөхөн төлбөрт төлсөн бөгөөд судалж байгаа болон материал бүрдүүлж өгч амжаагүй таамагласан 0.6 тэрбум төгрөг нөхөн төлбөрт нөөц байгуулж нийт 6.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг зардалд тооцсон. Хохирлын харьцаа нь 45% буюу салбарын дундажаас 5%-иар илүү байна.

НИЙТ ХУРААМЖИД НОГДОХ НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ /ХАРЬЦУУЛАЛТ/



Мөн 2.1 тэрбум төгрөгийг даатгалын гэрээг түгээх, таниулах, брокер, төлөөлөгч нарт тараах, зуучлах зардалд төлсөн нь салбарын дунджаас 3 пункт бага байна.

Даатгалын үндсэн үйл ажиллагааны зардлын дийлэнх хувийг цалин, түрээсийн зардал эзэлдэг бөгөөд энэ нь манай үндсэн үйл ажиллагааны зардлын 64%-ийг эзэлж байна.

Мэргэжлийн үйлчилгээ, давхар даатгал, гэнэтийн аврах ажиллагаа, бүтээгдэхүүний шимтгэл, зохицуулагч байгууллагын шимтгэл зэрэг зардлууд 23%, үлдсэн 13%-ийг бусад хэрэглээний зардал зэрэг зардлууд бүрдүүлдэг.

Ингээд нийтдээ Хосолсон харьцаа буюу нөхөн төлбөр, үйл ажиллагааны зардлаа орлогод тооцсон хураамжтай харьцуулсан харьцаа 105% гарсан. Өөрөөр хэлбэл Даатгалын үйл ажиллагаанаас -5% ашигтай гарсан.

Үүн дээр нэмэх нь Даатгуулагч нарын хураамж, нөөцөөс бүрдсэн мөнгөн хөрөнгө 13% -ийн өгөөжтэй ажилласан. Энэ дүн 2020 оны хугацаатай хадгаламжийн хүүгийн дунжаас 1.4%⁴ -иар өндөр байна. Судлах нөөц бололцоотой, мэргэшсэн үйл ажиллагаатай тул хууль журмын хүрээнд дунджаас илүү хувийн өгөөж олоход нөлөөлж байдаг.

(сая төгрөг)	Бодь даатгал	Эзлэх хувь	Салбарын нийт (Бодь даатгал ороогүй)	Эзлэх хувь
Орлогод тооцсон хураамж	14,760.0	100%	111,871.3	100%
Нийт нөхөн төлбөр	6,663.9	45%	43,613.6	40%
Үйл ажиллагааны зардал	6,665.4	45%	50,937.3	46%
Зуучлалын зардал	2,150.6	15%	19,453.7	17%
Нийт (Хосолсон харьцаа) ⁵	15,480.0	105%	114,004.6	102%


Даатгалын үйл ажиллагаанаас -0.6 тэрбум, давхар даатгалын шимтгэлээр 1.2 тэрбум, хүүгийн орлогоос 1.5 тэрбум нийтдээ 2.1 тэрбум төгрөгийн нийт орлоготой ажилласнаас 0.2 татвар шимтгэл төлж 1.9 тэрбумын цэвэр ашигтай гарлаа. Энэ эздийн өмчийн 14%-ийг эзэлж байна. Цаашид богино, дунд хугацаанд үйл ажиллагаа дээр дурьдсанаар хурдтай тэлж, өргөжилтийн үр өгөөж бий болсноор ашигт ажиллагаа хурдтай нэмэгдэх эерэг дүр зураг харагдаж байна.

2020 онд авлага, өглөгөө бууруулж, мөнгөн хөрөнгөө өсгөж ажилласан. Үндсэн хөрөнгө, технологийн хөрөнгө оруулалт сүүлийн 3 жилд бага зардлаар хийсэн бөгөөд, цаашдын 2-3 жилд хөрөнгө оруулалтын орлогод эзлэх хувийг өсгөхөөр төлөвлөж байна.

4. 2020 оны 6-р сарын байгууллагын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 11.6% – Монгол банк

5. Бодь даатгалын үйл ажиллагааны зардалын харьцаа нь салбарын дунджаас бага боловч хосолсон харьцаа нь өндөр гарч байгаа нь нөхөн төлбөрийг бусдаасаа илүү өгдөгөөс үүдсэн болно.

2021 нийт хөрөнгө 32.7 тэрбум төгрөг болсон. Цэвэр хөрөнгө 25.0 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оноос 8% өссөн үзүүлэлт болсон⁶.



АЛСЫН ХАРАА


Алсдаа бид хөрөнгө оруулагч нарт нээлттэй, нэвтрэлт багатай frontier улсад ажиллах жишиг болсон, дотоод, гадаададын хөрөнгийн биржийн листэд компани болох алсын хараатай. Энэ алсын хараанд хүрэхэд даатгалын нэвтрэлтийн хурдтай сайжруулах, орчин үеийн технологи, мэдлэгийн баазыг үр ашигтай ашиглаж харилцагчийн эрсдэлийг хаах даалгавартай ажиллаж байна.

6. Цэвэр хөрөнгө гэдэг нь баланс дээрх давхар даатгагчийн хариуцсан хэсгийг хассан дүн.

ХУВЬЦАА

2020 онд дотоодын хөрөнгийн биржийн 1-р самбарт гарч, ТОП-20 индекст орж хөрөнгө оруулагч нарт нээлттэй болсон. Мөн ажилчдадаа энэ оны эхний хагас жилд хувьцааны опцион эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

2020 оны 6-р сарын 9 нд 113 төгрөгөөр санал болгож оны эцсийн өдөр 129 төгрөгөөр арилжаалагдаж, 2020 онд 15% өгөөжтэй*, ногдол ашиг орсон дүнгээр жилийн 22.5% өгөөжтэй гарсан.



Бид манай хувьцаа нь хөрөнгө оруулагч нарын багцад эзлэх тохиромжтой, эрсдэл багатай, ирээдүйн өсөлт сайтай гол хувьцаануудын нэг байх ёстой гэж үзэж байгаа.

Үзүүлэлт	Тийм
Самбар:	MSE I
Орсон индекс:	ТОП 20
Хяналт, зохицуулалт:	СЗХ, Хөрөнгийн бирж, Аудит
Орлого, ашиг Сүүлийн 3 жилд дараалж өссөн эсэх:	тийм
Эдийн засгийн уналтаас хамаарал:	Бага
Шинэ оролцогчийн эрсдэл:	Тусгай зөвшөөрөлтэй, зохицуулалттай салбар
Менежментийн туршлага:	Гүйцэтгэх удирдлага, даатгалын захирал 10 дээш жил ажилласан.

* — Нийт өгөөж = $\left(\left(\frac{\text{Оны эцсийн үнэ} + \text{Ногдол ашиг}}{\text{IPO үнэ}} \right)^{\frac{365}{4/30/2021 - 4/9/2020}} \right) - 1$

